

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Монгол ардын намын хорооны

2020 оны орон нутгийн сонгуульд дэвшүүлэх мөрийн хөтөлбөр

Хөгжлийн түвшингээр улсын тэргүүний сумын жишигт хүрсэн, иргэд нь ажилтай, орлоготой, эрүүл аюулгүй, тохилог амьдрах орчин нөхцөл бүрдсэн **ЖИШИГ СУМ** болгох нь сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрийн үндсэн зорилго байна.

Нэг. Эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого

1.1 Санхүү, төсвийн бодлого

1.1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний төлөвлөлтийг боловсронгуй болгох, төлөвлөгөөний хэрэгжилтийг жигд ханган биелүүлэх ажлыг зохион байгуулна.

1.1.2 Орон нутгийн төсөв, санхүүгийн орлого зарлагын мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх, шилэн дансны хуулийг төрийн болон төрийн өмчийн оролцоотой бүх байгууллага аж ахуйн нэгжийн хүрээнд хэрэгжүүлж хэвшүүлнэ.

1.1.3 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажлын гүйцэтгэл, үр дүнд тавих хяналтыг **тогтмолжуулна**.

1.1.4 Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг сумын хөгжлийн хэтийн төлөв, иргэдийн санал хүсэлтэд тулгуурлан төлөвлөж хэрэгжүүлнэ.

1.1.5 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, тогтвортой ажлын байрыг бий болгох, өрхийн тогтвортой орлого бий болгох үндсэн шалгуураар олгож гүйцэтгэлийн хяналт шалгалтыг сайжруулна.

1.2 Бүтээн байгуулалт

1.2.1 Сумын хэмжээнд

1.2.1.1 “Хөгжлийн төлөө хамтдаа” аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дүгнүүлдэг ажлыг хэвшүүлнэ.

1.2.1.2 Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар иргэн, аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, санаачлагыг бодлогоор дэмжиж ажиллана.

1.2.1.3 Буурал, Салхит багуудын үерийн даланг сэргээн засварлах, шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.

1.2.1.4 Дугуйн зам, явган хүний зам, авто машины зогсоолыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

1.2.1.5 Хүүхэд, залуучуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлж тоглоомын талбай, тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1.2.1.6 “Эмт наран” ОНӨААТҮГ-ын төвлөрсөн усан хангамжийн цахилгааны шугамын шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэж найдвартай ажиллагааг хангана.

1.2.1.7 Гэр хорооллын төвлөрсөн сүлжээнд холбогдсон ус түгээх цэгүүдийг түгээлтийн автомат горимд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

1.2.1.8 Гэр хорооллуудад Био жорлон төслийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлнэ.

1.2.1.9 Суманд орчин үеийн мэдээллийн технологийн ололт амжилтыг нэвтрүүлэх бодлого баримталж хэрэгжүүлнэ. /Сумын төвд Юнивишн, Хүйтэн, Мухар, Зулзагын голд үүрэн утасны сүлжээ байгуулах/

1.2.2 Буурал /1-р баг/ багт хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд

1.2.2.1 Соёл, урлагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэхэд анхаарч, соёл, урлагийн үйлчилгээний тоог нэмэгдүүлж соёлын төвийн барилгын шинэчлэлийг хийж гүйцэтгэнэ.

1.2.2.2 Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг хийж гүйцэтгэнэ.

1.2.2.3 Сумын төвийн авто замыг хатуу хучилттай болгох ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.2.2.4 Сумын төвийн гэр хорооллыг дэд бүтцэд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.2.2.5 Сумын төвийн цэвэрлэх байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.2.2.6 Сумын төвийн нийтийн орон сууцнуудыг хэрэглээний халуун устай болгож, ундны усны хатуулгийг бууруулах технологи нэвтрүүлнэ.

1.2.2.7 Үер ус, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 1 дүгээр багийн үерийн далангийн засвар шинэчлэлтийг хийж гүйцэтгэнэ.

1.2.2.8 Сумын төвд амины орон сууцны шинэ суурьшлын бүс байгуулна.

1.2.2.9 Алслагдсан хэсгүүдийн хүн амын хэрэгцээ шаардлагад тулгуурлан халуун усны газруудыг сэргээгдэх эрчим хүчийг ашиглан байгуулна.

1.2.3 Зулзага /2-р баг/ багт хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд

1.2.3.1 Зулзага багийн төвийг цахилгааны нэгдсэн шугамд холбож алслагдсан багийн иргэддээ хүрч үйлчилнэ.

1.2.3.2 Нүүдлийн гол зам давааг засах ажлыг малчдын саналд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.2.4 Салхит /3-р баг/ багт хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд

1.2.4.1 Хонгор-Салхит чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг дуусгаж ашиглалтанд оруулна.

1.2.4.2 Салхит багт хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж спорт цогцолборыг барьж байгуулна.

1.2.4.3 Салхит багт цэцэрлэгийн өргөтгөл барьж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

1.2.4.4 Салхит багийн нийтийн орон сууцны хороолол доторх авто замыг хатуу хучилттай болгох ажлыг үргэжлүүлэн хийж гүйцэтгэнэ.

1.2.4.5 Салхит багийн гэр хорооллыг дэд бүтцэд холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.

1.2.4.6 Салхит багийн нийтийн орон сууцнуудын дээвэр засварын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.4.7 Салхит багийн эрүүл мэндийн амбулаторийн иргэдэд үйлчлэх нөхцөл боломжийг сайжруулна.

1.2.4.8 Сумын төвд хэрэгжсэн Манай сум-Миний гэр төслийг Салхит багт хэрэгжүүлнэ.

1.2.4.9 Үер ус, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 3-р багт үерийн далангийн засвар шинэчлэлтийг хийж гүйцэтгэнэ.

1.2.4.10 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Салхит багийн хяналтын камерын ажиллагааг сайжруулж камерын тоог нэмэгдүүлнэ.

1.2.4.11 Эрхэт хэсэгт халуун усны газрыг сэргээгдэх эрчим хүчийг ашиглан байгуулна.

1.2.4.12 Эрхэт хэсэгт гэр цэцэрлэг ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

1.2.4.13 Салхит багийн наадмын талбайг шинэчлэх ажлыг Төмөр замын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Хоёр. Жижиг, дунд үйлдвэрлэл, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого

2.1 Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж, шаардлага хангасан аж ахуйн нэгж, иргэдэд **бага хүүтэй зээл олгох чиглэлээр тусгайлсан хөтөлбөр** боловсруулж хэрэгжүүлэн дэмжиж ажиллана.

2.2 Суманд **“Бизнес инкубатор төв”**-ийг байгуулж бичил бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжин төрөл бүрийн жижиг үйлдвэр, цехүүдийг байгуулан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.3 Ажилгүй иргэдийг мэргэжил, боловсрол, сонирхлын дагуу нэгдсэн бүртгэлд хамруулж, 1000-аас доошгүй байнгын болон түр ажлын байр бий болгох зорилт дэвшүүлэн **Ажлын байрыг дэмжих хөтөлбөр** гаргаж хэрэгжүүлнэ.

2.4 Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, баялаг бүтээгчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, тогтвортой, үр ашигтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэхэд төрийн зүгээс дэмжиж ажиллана.

2.5 Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны иргэдийг мэргэшүүлэх, ур чадварыг нь ахиулах богино хугацааны сургалтанд хамруулж, **хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.**

2.6 Их, дээд сургуулиудад зарим төрлийн нэн шаардлагатай нарийн мэргэжлийн хүмүүсийг орон нутгийн захиалгаар гэрээгээр бэлтгэж, тогтвортой ажлын байраар хангах зорилгоор **“Захиалгат мэргэжилтэн”** төсөл хэрэгжүүлнэ.

Гурав. Хүнс, хөдөө аж ахуйн бодлого

Газар тариалангийн чиглэлээр

3.1.1 Газар тариаланг эрчимжсэн мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх бодлого баримтална.

3.1.2 **“Атар-4”** аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.1.3 Газар тариалангийн салбарт тогтвортой үйл ажиллагаа эрхэлж орон нутгийн иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангаж буй аж ахуйн нэгжүүдийг хуулийн хүрээнд бүх талаар дэмжиж хамтран ажиллана.

3.1.4 Атрын 4-р аяны хүрээнд сумынхаа иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор **“Газар тариалан, төмс хүнсний ногооны дундын аж ахуй”** байгуулах ажлыг судалж шийдвэрлэх бодлого баримтална.

3.1.5 Үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнээ дахин боловсруулах талаар гарсан санал санаачлагуудыг бүх талаар дэмжиж ажиллана.

3.1.6 Газар тариалан, мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлэх бодлогыг тогтвортой хэрэгжүүлнэ.

3.1.7 Газар тариалан эрхлэгчид жилд тариалах талбайнхаа 20-оос доошгүй хувьд тэжээлийн ургамал тариалдаг бодлого хэрэгжүүлнэ.

3.1.8 Төмс хүнсний ногооны нэгдсэн талбайн ашиглалтыг сайжруулан ус, цахилгаан, хашаа хамгаалалтын ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан бүрэн шийдвэрлэнэ.

3.1.9 Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хөрсний элэгдлийг бууруулах бодлого баримтална.

3.1.10 Газар тариалан эрхлэгчидтэй хамтран ойн зурвас байгуулах замаар цөлжилттэй тэмцэх, хөрсний элэгдлээс хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.1.11 Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжүүдийн гаргасан санаачлагыг бодлогоор дэмжинэ.

3.1.12 **“Хүлэмжийн аж ахуй”, “Туслах аж ахуй”-г** дэмжих дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2 Мал аж ахуйн чиглэлээр

3.2.1 Бэлчээр хамгаалах, бэлчээрийн зохистой ашиглах журмын хэрэгжилтийг хангуулна.

3.2.2 Алслагдсан бэлчээрийг усжуулах замаар бэлчээр ашиглалтыг сайжруулах бодлого баримтална.

3.2.3 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжиж малын ашиг шимийг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2.4 Малын удмын сангийн үндэсний цогцолборын үйл ажиллагаанд тулгуурлан бод малын үүлдэр угсааг сайжруулах ажлыг тогтмолжуулна.

3.2.5 Малын халдварт өвчингүй бүс нутаг болох зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3.2.6 Малын халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх бааз суурийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. /угаалга ариутгалын багаж хэрэгсэл, вакцинжуулалтын хашаа, мал угаах ванн гм/

3.2.7 Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малын сүү авах цэг, сүлжээг байгуулах ажлыг аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого

4.1 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтална.

4.2 Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулах орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд аялал жуучлал, амралт сувиллын зориулалтаар ашиглуулах бодлого баримтална.

4.3 Сумын хэмжээнд усны нөөц, гол мөрөн, булаг шандны урсац бүрэлдэх эхийг хамгаалах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

4.4 Голын ай сав дагуу цөлжилт эрчимтэй явагдаж байгаа газруудыг ойжуулах санал санаачлагыг бүх талаар дэмжин ойн санг нэмэгдүүлж, **100**–аас багагүй га талбайд ойжуулалт хийнэ.

4.5 Төв суурин газруудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж иргэн, айл өрх, ойн нөхөрлөлүүд болон ойн мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

4.6 Хараа голын сав дагууд болон ойн сан бүхий газруудад тархсан хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг **3000** – аас доошгүй га талбайд хийнэ.

4.7 Ахуйн хог хаягдлыг ангилдаг, хог хаягдлыг дахин боловсруулж зах зээлд нийлүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.

4.8 Уул уурхай, үйлдвэрлэлийн улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг тогтмол хийнэ.---

4.9 Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх, зөрчил илрүүлэх хяналт шалгалтыг тогтмолжуулах, үнэ цэнэ бүхий мэдээллийг үнэлгээжүүлэх, нууцыг хадгалах ажлыг холбогдох газруудтай хамтран шийдвэрлэнэ.

Тав. Нийгмийн бодлого

5.1 Боловсрол, соёл, спортын чиглэлээр

5.1.1 Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг эрс сайжруулна.

5.1.2 Ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн хичээлийн Б байрны сантехникийн болон барилгын их засварын зураг, төсвийг боловсруулж холбогдох газруудад нь уламжилж шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

5.1.3 Ерөнхий боловсролын сургуулиудын гадна спортын талбайг шинэчлэх ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.

5.1.4 Цэцэрлэг, сургууль бүрийн материаллаг баазыг сайжруулж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурах нөхцлийг бүрдүүлнэ.

5.1.5 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэдлэг, чадвар, заах арга зүйг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах зорилгоор **“Багшийн хөгжлийг дэмжих”** сумын дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.1.6 16 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн барилгыг ашиглалтад оруулж ясли, 24 цагийн бүлгийг шинээр ажиллуулах бодлого баримталж хэрэгжүүлнэ.

5.1.7 Орчин үеийн шаардлагад нийцсэн кино театр, номын сан, музей, хөгжим, бүжгийн дугуйлан хичээллүүлэх боломжтой соёлын төвийг шинээр барьж ашиглалтад оруулна.

5.1.8 Орон нутгийн түүх, соёл, байгаль, хөгжлийн онцлогийг харуулсан урлаг, соёлын бүтээл, туурвилыг нийтийн хүртээл болгоход нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

5.1.9 **“Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх”** сумын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн төрөл бүрийн секц дугуйлан хичээллүүлж материаллаг баазыг нэмэгдүүлэх, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчдыг дэмжих бодлого баримтална.

5.1.10 Сургуулийн автобусны үйлчилгээг өргөжүүлж, цэцэрлэгийн хүүхдийн автобустай болно.

5.1.11 Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж буй сурлагын амжилтаараа тэргүүлэгч оюутнуудад зориулсан “Тэтгэлэгт хөтөлбөр” хэрэгжүүлнэ.

5.2 Эрүүл мэндийн чиглэлээр

5.2.1 Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг цаг үед нь нийцүүлэн шинэчлэх, боловсон хүчний хангамж, чадамжийг сайжруулах замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

5.2.2 Хөдөөгийн багийн өрхийн эмнэлгийн түргэн тусламжийн парк шинэчлэлийг шийдвэрлэнэ.

5.2.3 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх дадал заншлыг хэвшүүлэх сургалт сурталчилгааг чанаржуулах, гарах үр дүнг сайжруулах арга хэмжээ авна.

5.2.4 Сумын Эрүүл мэндийн төвийг ариутгал халдваргүйжүүлэлтийн болон лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах /биохимийн анализатор, өрөө тасалгааны их загвар, өргөтгөлийн асуудлыг шийдвэрлэнэ.

5.3 Нийгмийн хамгааллын чиглэлээр

5.3.1 Залуучууд, ахмадуудын талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн үр өгөөжийг сайжруулна.

5.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг сайжруулж тэдэнд ээлтэй орчныг бүрдүүлэх бодлого баримтлан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн танхим”-ыг ажиллуулна.

5.3.3 Зорилтот бүлгийн иргэдийг олон улсын төсөл хөтөлбөрүүдэд хамруулах замаар амьдралын чанарыг нь сайжруулах арга хэмжээ авна.

5.3.4 Суманд үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн /ахмадын хороо, эмэгтэйчүүдийн холбоо гэх мэт/ байгууллагуудын үйл ажиллагаа дэмжиж хамтарч ажиллана.

5.3.5 “Ахмадын сан”-ийн хамрах хүрээг нэмэгдүүлэн ахмадын байгууллагын үйл ажиллагаа, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зэрэг асуудлуудыг шийдвэрлэдэг журмыг хэрэгжүүлнэ.

5.4. Гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр

5.4.1 Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүл дэх хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.

5.4.2 Гэр бүлийн гишүүд, ялангуяа эцэг, эхчүүдийн хариуцлагыг дээшлүүлж, хүүхэд гэр бүл дотроо амар тайван өсч хөгжих боломж, нөхцлийг хангуулна.

5.4.3 Хүүхдийг багаас нь амьдрах ухаанд сургаж, ирээдүйд харилцааны зөв хэвшилтэй, ёс зүйтэй, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхийг бодлогоор дэмжинэ.

Зургаа. Төрийн удирдлагын бодлого

6.1 Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

6.2 Сумын ЗДТГазарт “Чанарын менежментийн тогтолцоо”-г бүрэн нэвтрүүлж үр дүнг тооцно.

6.3 Төрийн бүх шатны байгууллагаас гаргаж буй шийдвэр нь зөвхөн ард иргэдийн санаа бодолд тулгуурласан байх зарчмыг баримтална.

6.4 Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэн, аж ахуйн нэгжээс гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, шийдвэрлэлтийн явц, хэрэгжилтийг цахимаар хянадаг болно.

6.5 Төрийн бүх шатны байгууллагууд, ААН-ийн архивын бичиг баримтын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулж, стандартад нийцүүлнэ.

6.6 Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргаа, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах бодлого баримтална.

6.7 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сурган хөгжүүлж, мэдлэг, чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.

Долоо. Хууль эрх зүйн бодлого

7.1 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг сайжруулж гэмт хэрэг зөрчлийн тоо хэмжээг тууштай бууруулах бодлого баримтална.

7.2 Сумын цагдаагийн хэсгийн материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гаргасан үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжиж, цагдаагийн бие бүрэлдэхүүн, мэргэжлийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулна.

Найм. Гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого

8.1 Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөлтийг жил бүр тодотгож хэрэгжилтийг хангуулна.

8.2 Гамшиг эрсдэлийн үед ашиглах техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах, хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

8.3 Сумын аюулгүйн нөөцийг жил бүр бүрдүүлэх, нөхөн хангалт хийх замаар байнгын бэлэн байдалд байлгах арга хэмжээ авна.

Ес. Гадаад харилцаа, хангах ажиллагааг хөгжүүлэх бодлого

9.1 Хууль журмын дагуу хийгдэж буй гадаад, дотоодын хөрөнгө оруулалтуудыг бүх талаар дэмжиж хөрөнгө оруулалтын эцсийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд тавих хяналтыг сайжруулна.

9.2 Боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын гадаад дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого баримтална.

9.3 Төрийн бүх шатны байгууллагуудад дотоодын ижил түвшний байгууллагуудтай харилцан туршлага солилцох ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана.